



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Оточ мандал өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/001/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2026.03.15	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат	
	Утас: 70442584	Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор	М.Алтантуяа
	Утас: 99061829	Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор:	Б.Нарангэрэл
Утас: 99009293	Цахим хаяг: <a href="mailto:Narangerelb@audit.gov.mn">Narangerelb@audit.gov.mn</a>	
	Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
Хоёр. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	5
2.1 Төлбөрийн акт .....	5
2.2 Албан шаардлага .....	6
2.3 Зөвлөмж .....	7
Гурав. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	7
Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл .....	8

Оточ мандал өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нэг.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12 сарын 31
А	Б	1	2
1	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>763,202,068.28</b>	<b>678,462,179.35</b>
1.1	Эргэлтийн хөрөнгө	<b>142,807,646.11</b>	<b>101,216,891.72</b>
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,952,308.88	65,969,554.59
1.1.3	Татвар, ЭМД-ийн авлага	92,405,278.03	9,210,830.30
1.1.6	Бараа материал	42,450,059.20	26,036,506.83
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>620,394,422.17</b>	<b>577,245,287.63</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	611,694,422.17	568,545,287.63
1.2.2	Биет бус хөрөнгө	8,700,000.00	8,700,000.00
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>763,202,068.28</b>	<b>678,462,179.35</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>763,202,068.28</b>	<b>678,462,179.35</b>
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,480,000.00</b>	
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	6,480,000.00	
2.1.1.1	Дансны өглөг	6,480,000.00	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,480,000.00	-
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	6,480,000.00	-
2.3	<b>2. Эзэмшигчийн өмч</b>	<b>493,804,262.99</b>	<b>494,205,262.99</b>
2.3.1	Өмч: -төрийн	493,804,262.99	494,205,262.99
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,690,908.85	12,690,908.85
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	63,300,185.40	63,300,185.40
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	186,926,711.04	108,265,822.11
2.3.11	Эздийн өмчийн дүн	756,722,068.28	678,462,179.35
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>763,202,068.28</b>	<b>678,462,179.35</b>

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	978,561,107.6	925,588,199.9
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг /алдагдал/		
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	915,997,545.1	1,004,249,088.8
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		

Оточ мандал өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	62,563,562.5	-
19	Орлогын татварын зардал		78,660,888.9
20	Татварын дараах ашиг (алдагдал)	62,563,562.5	-
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		78,660,888.9
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	62,563,562.5	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		78,660,888.9

### 1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024оны 12 сарын 31	2025 оны 12сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.	Мөнгөн орлогын дүн (+)	909,859,577.55	1,017,884,487.63
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	254,208,250.00	338,392,178.03
	Татаас, санхүүжилтийн орлого	602,408,199.38	613,932,540.40
	Бусад мөнгөн орлого	53,243,128.17	65,559,769.20
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	878,396,542.04	947,240,441.92
	Ажилчдад төлсөн	395,701,099.00	450,287,866.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	112,633,348.00	119,087,593.60
	Бараа материал худалдан авахад төлсөн	174,262,990.00	71,263,551.00
	Ашиглалтын зардалд төлсөн /холбоо, бичиг хэргийн зардал/	38,258,856.81	65,981,445.00
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,885,000.00	9,555,000.00
	Татварын байгууллагад төлсөн	47,883,155.10	52,889,763.00
	Бусад мөнгөн зарлага	102,772,093.13	178,175,223.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,838,035.51	58,017,245.71
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	23,625,000.00	12,626,800.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	23,625,000.00	12,626,800.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,838,035.51	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	114,273.37	7,952,308.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,952,308.88	65,969,554.59

#### 1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31 үлдэгдэл</b>	<b>584,840,269.4</b>	<b>12,690,908.9</b>	<b>73,000,185.4</b>	<b>124,363,148.6</b>	<b>794,894,512.3</b>
Залруулсан үлдэгдэл	140,831,731.8		9,700,000.0		150,531,731.8
Тайлант үеийн цэвэр ашиг				62,563,562.5	62,563,562.5
Өмчид гарсан өөрчлөлт	49,795,725.4				49,795,725.4
<b>2024 оны 12 сарын 31 үлдэгдэл</b>	<b>493,804,263.0</b>	<b>12,690,908.9</b>	<b>63,300,185.4</b>	<b>186,926,711.0</b>	<b>756,722,068.3</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Тайлант үеийн цэвэр ашиг				- 78,660,888.9	- 78,660,888.9
Өмчид гарсан өөрчлөлт	401,000.0				401,000.0
<b>2025 оны 12 сарын 31 үлдэгдэл</b>	<b>494,205,263.0</b>	<b>12,690,908.9</b>	<b>63,300,185.4</b>	<b>108,265,822.1</b>	<b>678,462,179.4</b>

#### Хоёр. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 193,120.8 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тус байгууллага нь худалдан авсан 193,120.2 мянга, зарцуулсан 209,534.4 мянган төгрөгийн бараа материалын тайланг гаргаагүй байгаа нь НББОУС-2 Бараа материал, мөн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 60,366.8 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс 1,688.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 56,748.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,930.0 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

##### 2.1 Төлбөрийн акт

2.1.1 Тус байгууллагын дарга нь өөртөө шийдвэр гарган 1,449.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл авч, 239.0 мянган төгрөгийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Хууль зөрчиж шийдвэрийн дагуу олгосон 1,688.0 мянган төгрөгийг байгууллагын даргаар буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

## 2.2 Албан шаардлага

2.2.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн нягтлан бодогчийн орон тоог 0.5 аар баталсан байхад бүтэн орон тооны цалингаар цалинжсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/320 дугаар тушаалаар баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм” -ын 2.5-д “Төвийн дарга нь 1800-2200 иргэнд 1 өрхийн эмч, 1 өрхийн сувилагч ноогдохоор тооцон дархлаажуулалт, өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээ, статистик дүн бүртгэл болон бусад ажилтныг сонгож ажиллуулна”, “Оточ мандал” бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн дүрмийн 5.1 “Нөхөрлөлийн гишүүн эмч нар болон бусад ажилчдын сар бүрийн цалинг тухайн жилд нэг иргэний тоогоор батлуулсан төсвийн орлогын хэмжээг харгалзан жил бүрийн эхэнд тогтооно”, Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.1 “Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид нягтлан бодогчийн орон тоог хууль журамд нийцүүлэн баталж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.2.2 Тайлант онд илүү цагийн нэмэгдлийг ажилчдад олгохдоо хуульд зааснаас хэтрүүлэн 12,527.7 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4 "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна", 91 дүгээр зүйлийн 91.2 "Дараах тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид илүү цагийн нэмэгдлийг олгохдоо хууль журамд нийцүүлэн олгож байх, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.2.3 Монгол улсад өрхийн эмнэлэг үүсэж хөгжсөний 25 жилийн ойн спортын тэмцээн уралдаан, ур чадварын тэмцээнд зориулж 2,299.6 мянган төгрөгийг шийдвэргүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн



авсан ажилтан хариуцна”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид хөрөнгө зарцуулахдаа байгууллагын даргын шийдвэрээр зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

### 2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт 1:** Ажилчдын цалингаас хамтын сангийн 1,930.0 мянган төгрөгийн суутгасан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид ажилчдын цалингаас хуульд зааснаас бусад хэлбэрээр суутгал хийдэг байдлыг таслан зогсоож зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Гурав. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл							/мянган төгрөгөөр/			
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага нь худалдан авсан 193,120.2 мянга, зарцуулсан 209,534.4 мянган төгрөгийн бараа материалын тайланг гаргаагүй байна.	1	193,120.2	1	193,120.2			1	193,120.2		
Дүн	1	193,120.2	1	193,120.2			1	193,120.2		

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын дарга нь өөртөө шийдвэр гарган 1,449.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл авч, 239.0 мянган төгрөгийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байна.	1	1,688.0	1	1,688.0				
Өрхийн эрүүл мэндийн төвийн нягтлан бодогчийн орон тоог 0.5	1	41,921.5			1	41,921.5		

Оточ мандал өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

аар баталсан байхад бүтэн орон тооны цалингаар цалинжсан байна.								
Тайлант онд илүү цагийн нэмэгдлийг хуульд зааснаас хэтрүүлэн 12,527.7 мянган төгрөгийг олгосон байна.	1	12,527.7			1	12,527.7		
Монгол улсад өрхийн эмнэлэг үүсэж хөгжсөний 25 жилийн ойн спортын тэмцээн уралдаан, ур чадварын тэмцээнд зориулж 2,299.6 мянган төгрөгийг шийдвэргүйгээр зарцуулсан байна.	1	2,299.6			1	2,299.6		
Ажилчдын цалингаас хамтын сангийн 1,930.0 мянган төгрөгийн суутгасан байна.	1	1,930.0					1	1,930.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>60,366.8</b>	<b>1</b>	<b>1,688.0</b>	<b>3</b>	<b>56,748.8</b>	<b>1</b>	<b>1,930.0</b>

**Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ			1					
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>			<b>1</b>					

-----oOo-----